

## МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батдорж, Г. Билгээ

## 1. 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

## 1.1. Төсвийн хүрээний мэдэгдэл

Засгийн газар Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-д өргөн мэдүүлсэн холбогдох материалд Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлж 2012 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг дараах байдлаар өөрчлөх саналыг оруулсан байна:


## Хүснэгт 1.1. 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэлд оруулах өөрчлөлтийн санал

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Батлагдсан хуулийн дагуу1	Өөрчлөлт оруулах санал	Зөрүү, хувиар
1.	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	16.6	25.6	54.2
2.	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	9	9	0.0
3.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ / тэрбум төг./	4,176.1	6,352.2	52.1
	• ДНБ-д эзлэх хувь	29.8	35.3	18.5
4.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ / тэрбум төг./	5,113.5	7,093.1	38.7
	• ДНБ-д эзлэх хувь	36.5	39.4	7.9
5.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ / хувь/	25.2	3,009.0	11840.5
	• ДНБ-д эзлэх хувь	7.3	16.7	128.8
6.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл / тэрбум төг./	-937.4	-740.9	-21.0
	• ДНБ-д эзлэх хувь	-6.7	-4.1	-38.8
7.	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ / тэрбум төг./	1,098.3	2,390.9	117.7
	• ДНБ-д эзлэх хувь	7.8	13.3	70.5
8.	Улсын өрийн нийт хэмжээ / тэрбум төг./	7,277.5	9,901.1	36.1
	• ДНБ-д эзлэх хувь	51.9	55.0	6.0
9.	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ / тэрбум төг./	218.8	222.5	1.7
	• ДНБ-д эзлэх хувь	1.8	1.2	-33.3

## 1.2. 2012 оны нэгдсэн төсөв


Төсвийн зарлагыг зохистой түвшинд хязгаарлан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлж, төсвийг алдалгүй байлгах Засгийн газрын бодлого 2012 оны төсвийн төлөд биелэлээ олоогүй байна. Төсвийн нийт тэнцлийн алдагдал бүтцийн хувьд улсын төсвийн алдагдал ХХС-ийн алдагдал байна. Төсвийн алдагдалыг Засгийн газрын бонд шинээр гаргах, гадаад төслийн зээлээр санхүүжүүлэхээр тооцжээ. Иймд нийт тэнцлээр алдагдалтай байгаа төсвүүдийн тооцоо дахин нягтлан үзэх хэрэгтэй.

Зураг 1.1. Монгол Улсын нэгдсэн төсөв – 2003-2012 он (Тэрбум төгрөгөөр)



Монгол Улсын нэгдсэн төсвийн төслийн үр дүн ДНБ-д эзлэх хувиар буурсан нь 2012 оны ДНБ-ий үзүүлэлт 18.003,3 тэрбум төгрөг болж 2011 оныхоос 43.6 хувиар өссөнтэй холбоотой.

Зураг 1.2. Монгол Улсын нэгдсэн төсөв, 2003 - 2012 он (ДНБ-нд эзлэх хувиар)



\*\*\*

## 2. 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСЛИЙН ОРЛОГО

### 2.1. 2012 оны нэгдсэн төсвийн нийт орлогын үзүүлэлт

2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн тогтвортой байдлыг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон орлогоор хуримтлал үүсгэх зорилгоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг хоёр дахь жилдээ тооцож, 2012 нэгдсэн төсөвт тусгасан байна.

Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт орлогын хэмжээ 2011 оны тодотголоос 61.5 хувь, нийт тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 62.0 хувь, тогтворжуулалтын сан 57.4 хувиар тус тус нэмэгдүүлэн тооцсон байна. Ийнхүү нэмэгдсэн боловч ДНБ -д эзлэх хувиар буурсан нь 2012 оны ДНБ-ий үзүүлэлт 2011 оныхоос 43.6 хувиар өссөнтэй холбоотой. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн баялгийг “гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого” гэдэгт зэс болон нүүрснээс төвлөрөх орлого хамаарч байна.

Хүснэгт 2.1.

- **Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн төслийн орлогын үр дүнгийн үзүүлэлт**

	Дүн /тэр.төг/		ДНБ-д эзлэх хувь	
	2011 Тод.	2012 Төсөл	2011 Тод.	2012 Төсөл
Нийт орлого ба тусламжийн дүн	4,139.0	6,733.4	40.7	37.4
Тогтворжуулалтын сан	219.0	381.2	2.2	2.1
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	3,919.9	6,352.2	38.6	35.3
Урсгал орлого	3,908.3	6,271.4	38.5	34.8
Татварын орлого	3,472.3	5,166.8	34.2	28.7
1. Орлогын албан татвар	762.7	1,039.4	7.5	5.8
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	408.4	548.0	4.0	3.0
3. Өмчийн татвар	12.4	15.9	0.1	0.1
4. Нэмэгдсэн өртөгийн албан татвар	1,091.8	1,678.9	10.7	9.3
5. Онцгой албан татвар	308.1	361.1	3.0	2.0
6. Тусгай зориулалтын орлого	19.6	36.4	0.2	0.2
7. Гаалийн албан татвар	344.0	792.1	3.4	4.4
8. Бусад татвар	525.4	695.1	5.2	3.9

Татварын бус орлого	408.4	1,104.6	4.3	6.1
Хөрөнгийн орлого	3.3	0.8	0.0	0.0
Тусламжийн орлого	8.6	80.0	0.1	0.4

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу 2012 онд эрдэс баялгийн үнийн өсөлтийг харгалзан Тогтворжуулалтын санд 381,2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төсөвлөсөн нь 2011 оны тодотголоос 42 хувиар нэмэгдүүлж тооцсон бөгөөд 2012 оны эцэст тус сангийн нийт хуримтлал 600.2 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Засгийн газар олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас зарладаг үнийн төсөөлөлд үндэслэн ашигт малтмалын үнийг тэнцвэржүүлсэн үнээр авч тооцсон бөгөөд 2012 оны төсөвт эрдэс баялгийн зах зээлийн үнийг дараах байдлаар тооцсон байна:

	ам.доллар
• алт	1723.7
• зэс	9760.5
• боловсруулсан нүүрс	199.9
• коксжих нүүрс	135.0
• чулуун нүүрс	88.9
• хүрэн нүүрс	75.0

Монгол Улсын хувьд ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт 2002 оны байдлаар нийт экспортын 50 орчим хувийг эзэлж байсан бол өнөөдөр 90 орчим хувийг эзэлж байна. 2012 оны төсөвт уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас 1,669.5 тэрбум төгрөгийн орлогыг төсөвлөсөн нь нийт тэнцвэржүүлсэн орлогын 42 хувийг эзэлж байна. Энэхүү уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын нийт орлогын 925.1 тэрбум төгрөг буюу 55 хувь нь нүүрснээс орох орлого байна. Үлдсэн уул уурхайн салбараас орох татварын орлогын 35 хувийг зэс, 6 хувийг төмрийн хүдэр, 4 хувийг алт, цайр, жонш зэрэг бусад бүрэлдэхүүн бүрдүүлнэ. Эндээс үзэхэд 2012 оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд зэсийн орлого бус нүүрсний орлого тэргүүлж байна.

2012 оны төсвийн төсөлд нийт тэнцвэржүүлсэн орлогод урсгал орлого 98,8 хувь, хөрөнгийн орлого 0,012 хувь, тусламжийн орлого 1,2 хувийг тус тус эзэлж байна. Ирэх оны урсгал орлогт 6,271.4 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголтой харьцуулахад 38.0 хувиар нэмэгдүүлсэн. Урсгал орлогын 81.3 хувийг татварын орлого, 17.7 хувийг татварын бус орлого тус тус бүрдүүлж байна.

## 2.2. Татварын орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн дийлэнхийг хувийг бүрдүүлж байдаг татварын орлогыг 2012 оны нэгдсэн төсвийн төсөлд 2011 оныхоос 1,694.5 тэрбум төгрөг буюу 32.8 хувиар нэмэгдүүлсэн байна. 2006-2010 онд татварын орлогын дийлэнхи хувийг бүрдүүлж байсан Орлогын албан татварын орлого сүүлийн хоёр жил буурсан бол НӨАТ-ын орлого өссөн байна. Ирэх жилийн татварын орлогын бүрэлдэхүүнийг 2011 оны тодотголтой харьцуулахад Гаалийн албан татвар – 56.6 хувь, Тусгай зориулалтын орлого 46.1 хувиар тус тус нэмэгдүүлэн тооцсон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын орлогыг төрлүүдээр нь дэлгэрүүлэн авч үзье.

Зураг 2.1. Татварын орлогын бүтэц – 2003-2012 он

2012төс	20	11	0	32	7	1	15	14	
2011тод	22	12	0	31	9	1	10	15	
2010	36		12	1	22	10	1	7	11
2009	33		16	1	20	11	1	7	12
2008	40		12	1	20	9	1	8	10
2007	43		11	1	28	9	1	7	11
2006	43		10	1	21	9	1	6	10
2005	26	14	1	26	12	2	8	12	
2004	25	14	1	28	12	2	8	11	
2003	24	16	1	29	14	2	8	7	

Орлогын албан татвар

НД-ын орлого

Өмчийн татвар

НӨАТ

ОАТ

Тусгай зориулалтын орлог

Гаалийн татвар

Бусад атвар

### 2.2.1. Орлогын албан татвар

2006-2010 онд татварын орлогын дийлэнхи хувийг буюу 36-43 хувийг бүрдүүлж байсан Орлогын албан татварын орлого сүүлийн хоёр жил буурч 2012 онд 20 хувь болсон байна. 2012 оны төсвийн төсөлд орлогын албан татварын орлого 2011 оны төсвийн тодотголтой харьцуулахад 276,7 тэрбум төгрөг буюу 26,6 хувиар нэмэгдүүлсэн байна.

2012 оны төсвийн төсөлд Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын орлого 2011 оныхтой харьцуулахад 30.6 хувиар өсөж байгаа нь аж үйлдвэрийн бүтэгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, тэр дундаа уул уурхайн салбарын өсөлттэй холбоотой аж. Хүн амын орлогын албан татварын 2012 оны орлогыг 2011 оныхтой харьцуулахад 38.0 хувиар нэмэгдэхээр байгаа нь төрийн албан хаагчдын цалинг шатлалаар нэмэгдүүлэх болсонтой холбоотой. Мөн уул уурхайн салбарын бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, ажлын байр шинээр нэмэгдэж байгаа нь нөлөөлж байна.

### 2.2.2. Нийгмийн даатгалын орлого

Ирэх жилийн нэгдсэн төсвийн төсөлд Нийгмийн даатгалын орлогыг 2011 оныхтой харьцуулахад 139.6 тэрбум төгрөг буюу 25.5 хувиар нэмэгдүүлсэн байна. 2012 оны нэгдсэн төсөвт Нийгмийн даатгалын шимтгэлээс орох орлого 2011 оны тодотголтой харьцуулахад Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 29.0 хувь, Эрүүл мэндийн даатгалын хураамжийн орлого 11.5 хувиар нэмэгдүүлсэн байна.

Зураг 2.2. Орлогын албан татварын бүтэц (Тэрбум төгрөгөөр)



Зураг 2.3. Нийгмийн даатгалын орлогын бүтэц (Тэрбум төгрөгөөр)




\*\*\*

### 2.2.3. Өмчийн татвар

2012 оны Өмчийн татвараас орж ирэх орлого нь 2011 оныхтой харьцуулахад 22.0 хувиар нэмэгдүүлсэн байна. Орон нутгийн төсөвт 2012 онд Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогоор 15.7 тэрбум төгрөг, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогоор 25.9 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлэхээр тусгасан байна.

### 2.2.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар

2006-2010 онд НӨАТ-ын орлого татварын орлогын 28-20 хувийг бүрдүүлж байсан бол 2012 онд дийлэнхи хувийг буюу 32 хувь болсон бөгөөд 2011 оны тодотголтой харьцуулахад 30.0 хувиар өссөн байна. Ирэх онд төсөвт Нэмэгдсэн өртгийн албан татвараас хамгийн их орлого орохоор төсөвлөсөн бөгөөд 2011 оны төсвийн тодотголоос 587,1 тэрбум төгрөг буюу 35 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна. Үүнд Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 36 хувиар, Импортын барааны НӨАТ -ын орлогыг 30 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон байна.



Ийнхүү нэмэгдэж байгаа нь уул уурхайн салбарын эрчимтэй хөгжил, стратегийн томоохон ордын бүтээн байгуулалтын ажилтай уялдан дотоодын барааны худалдан авалт болон хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл ихээр орж ирж байгаа зэрэг нь дотоодын болон импортын барааны НӨАТ-ууд нэмэгдэхээр тооцоолсон байна.

## 2.2.5. Онцгой албан татвар

2012 оны төсөвт ОАТ-ын орлогыг 2011 оны тодотголтой харьцуулахад 53.0 тэрбум төгрөг буюу 14.7 хувиар нэмэгдүүлэхээр төсөвлөсөн байна. Үүнд дотоодын пивоны ОАТ-аар 2012 онд 23.3 тэрбум төгрөг төвлөрөхөөр тусгасан байна. Дотоодын пивоны үйлдвэрлэлийн хэмжээ 2008-2010 оны хооронд 19.9 сая литрээс 44.8 сая литр болж нэмэгдсэн нь бусад ижил төрлийн барааны үйлдвэрлүүдээс хамгийн их буюу 55 хувиар нэмэгдсэн байна.

Мөн 2012 оны улсын төсөвт архи, тамхины болон пивоны ОАТ-ын орлогоос нийт 53.1 тэрбум төгрөгийн орлого нэмэгдэхээр байгаа нь 2011 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 29-31 хувиар нэмэгдэхээр байна. 2011 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 41700 суудлын автомашин импортлохоор тооцолж байгаа нь сүүлийн 4 жилийн дунджаас 50 гаруй хувиар өссөн, түүнчлэн Засгийн газраас УИХ-д өргөн бариад байгаа Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу 101,5 тэрбум төгрөгийг ОАТ-ын орлогоор улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна. Автобензин, дизелийн түлшний хэрэглээ жил ирэх бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2012 оны төсөвт автобензин, дизелийн түлшний албан татварын орлогоор 69.0 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Зураг 2.2. Онцгой албан татварын үзүүлэлт, 2010 - 2012 (Тэрбум төгрөгөөр)


	2010	2011 Тод.	2012 Төсөв
Онцгой албан татвар	268.5	308.1	361.1
Дотоодын архины	68.0	79.5	91.9
Импортын архи, тамхины	24.8	31.3	44.1
Импортын пивоны	5.1	6.2	9.0
Суудлын автомашины	54.5	89.4	101.5

Автобензин, дизель түлшний	92.5	65.1	69.0
Дотоодын тамхины	11.3	15.6	19.1
Дотоодын пивоны онцгой	12.2	21.0	26.6

### 2.2.6. Тусгай зориулалтын орлого

2012 оны нэгдсэн төсвийн төсөлд Тусгай зориулалтын орлогоор 361.1 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголтой харьцуулахад 16.8 тэрбум төгрөг буюу 46.1 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна. Уул уурхайн томоохон төслийн бүтээн байгуулалт эхэлж байгаагийн зэрэгцээ барилгын салбар, газар тариалангийн салбар сэргэж байгаатай холбогдож нефть бүтээгдэхүүний хэрэглээ өсөх хандлагатай бөгөөд 2012 оны төсөвт автобензин, дизелийн түлшний албан татварын орлогоор 10.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгасан байна.

Зураг 2.5. Тусгай зориулалтын орлогын бүтэц (Тэрбум төгрөгөөр)



Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын орлогоор нийт 25.9 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголоос 58.3 хувиар өссөн байна. Үүний 8.3 тэрбум төгрөгийн орлого нь Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын тухай хуулийн өөрчлөлтөөр нэмж төвлөрхөөр байна.


### 2.2.7. Гаалийн албан татвар

2012 оны нэгдсэн төсвийн төсөлд Гаалийн албан татварын орлогоор 792.1 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголтой харьцуулахад 448.1 тэрбум төгрөг буюу 56.6 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна. Мөн Гаалийн албан татварын орлого нь ДНБ-нд эзлэх хувиар 2011 оныхтой харьцуулахад 22.7 хувиар өссөн байна. Ийнхүү нэмэгдэхэд Импортын барааны гаалийн албан татварын орлого 2011 оныхтой харьцуулахад 37 хувь, Экспортын гаалийн албан татварын орлого 100 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.

Экспортын гаалийн албан татварын орлогын хувьд Засгийн газраас УИХ-д өргөн бариад байгаа Зарим барааны экспортын гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан тохиолдолд нийт 305.1 тэрбум төгрөг төвлөрөх бөгөөд үүнээс улсын төсөвт 246.5 тэрбум төгрөг, Тогтворжуулах санд 58.7 тэрбум төгрөг төвлөрөхөөр байна.




Зураг 2.5. Гаалийн албан татварын бүтэц (Тэрбум төгрөгөөр)



### 2.2.8. Бусад татвар

Ирэх оны нэгдсэн төсвийн төсөлд Бусад татвар /төлбөр, хураамж/-ын орлого 2011 оны тодотголтой харьцуулахад 169.7 тэрбум төгрөг буюу 24.4 хувиар нэмэгдүүлсэн байна. Бусад татварын орлогоор нийт 695.1 тэрбум төгрөг төсөвлөсөний 84.0 хувийг Улсын тэмдэгтийн хураамж, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг бүрэлдэхүүнүүдээс төвлөрүүлнэ. Эдгээрээс Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2011 оныхтой харьцуулахад хамгийн өндөр буюу 42.4 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна.

Зураг 2.5. Бусад татварын гол бүрэлдэхүүний үзүүлэлт (Тэрбум төгрөгөөр)



### 2.3. Татварын бус орлого


2012 оны нэгдсэн төсвийн төсөлд Татварын бус орлогоос 1,104.6 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголтой харьцуулахад 668.8 тэрбум төгрөг буюу 60.5 хувиар нэмэгдүүлсэн

байна. Мөн Татварын бус орлого нь ДНБ-нд эзлэх хувиар 2011 оныхтой харьцуулахад 29.5 хувиар өссөн байна. Ийнхүү нэмэгдэхэд Хувьцааны ногдол ашиг, Газрын тосны орлого болон Гарын үсгийн төлбөрийн орлогууд нөлөөлсөн байна. Тодруулбал, Гарын үсгийн төлбөрийн орлогыг 2011 оныхтой харьцуулахад 539.9 тэрбум төгрөг буюу 99.0 хувиар, Ногдол ашгийн орлого 84.0 тэрбум төгрөг буюу 55.2 хувиар, Газрын тосны орлого 25.0 тэрбум төгрөг буюу 26.4 хувиар өссөн байна.

#### 2.4. Хөрөнгийн ба Гадаад тусламжийн орлого

2012 оны нэгдсэн төсвийн Хөрөнгийн орлого 2011 оны тодотголтой харьцуулахад 2.5 тэрбум төгрөг буюу 76.4 хувиар буурсан байна. Харин ирэх оны төсөвт Гадаад тусламжийн орлого энэ оныхтой харьцуулахад 71.7 тэрбум төгрөг буюу 89.6 хувиар нэмэгдсэн төдийгүй мөн ДНБ-нд эзлэх хувийг харьцуулахад 75.0 хувиар өссөн байна. БНХАУ-ын Засгийн газраас манай улсад амалсан буцалтгүй тусламжийн мөнгөн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэл 412.1 сая юань буюу 80.0 тэрбум төгрөг аж.

Зураг 2.5. Бусад татварын гол бүрэлдэхүүний үзүүлэлт (Тэрбум төгрөгөөр)



\*\*\*

### 3. МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

#### 3.1. Нэгдсэн төсвийн зарлага

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хэмжээг жил бүр бууруулах бодлого хэрэгжүүлэх, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, төсвийн тодотголыг боловсруулах, батлахад улсын төсвийн нийт зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүний 33 хувиас хэтрүүлэхгүй байх, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын шинжтэй зарлагаас бусад зайлшгүй шаардлагатай бус урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, гадаад өрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах бодлогыг баримтлж төсвийн хүрээний мэдэгдэлд тусган боловсруулжээ.

Засгийн газар баримтдаж буй бодлогоо 2012 оны төсөвт хэрхэн тусгасныг авч үзье. Монгол улсын 2012 оны нэгдсэн төсвийн төсөлд шинжилгээ хийж 2003 оноос 2012 он хүртлэх зарлагын үзүүлэлтүүдийг харьцуулан өсөлт, бууралт, түүний хувь хэмжээг зарлага тус бүрээр нь гаргалаа.

Монгол улсын нийт зарлага ирэх онд 7093.1 тэрбум төгрөг, буюу ДНБ-ний 39.5 хувь байхаар төлөвлөж нийт зардлын хэмжээ нэмэгдсэн байна. Нийт зардал нэмэгдэхэд урсгал зардал 1341.6 тэрбум төгрөг буюу 40.7 хувиар, хөрөнгийн зардал 1203.9 тэрбум төгрөг буюу 101.4 хувиар тус бүр нэмэгдэж, эргэж төлөгдөх цэвэр зээл 364.8 тэрбум төгрөгөөр буурахаар төсөвлөгдөснөөс болжээ. Доорхи хүнэгтэд 2010-2012 оны нэгдсэн төсвийн зарлагын бүлгийн зардлууд өмнөх онынхоосоо хичнээн төгрөгөөр өссөн өсөлтийг харууллаа. /Хүснэгт 3.1/


Хүснэгт 3.1. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлт (Тэрбум төгрөгөөр)

			2010 Гүйц	2011 тод	2012 төс
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			603,1	828,2	2,180,7
A.	УРСГАЛ ЗАРЛАГА		394,2	149,1	1,341,6
	1.	Бараа, үйлчилгээний зардал	192,9	65,3	620,3
	1.1.	Цалин, хөлс	65,1	12,2	434,0
	1.3.	Нийгмийн даатгалын шимтгэл	0.0	0.0	0.0
	1.2.	Бараа, үйлчилгээний бусад зардал	127,8	53,1	186,3
	2.	Зээлийн үйлчилгээний төлбөр	0,9	0.0	153,7
	3.	Татаас ба урсгал шилжүүлэг	200,4	83,7	567,5
	3.1.	Татаас	37,0	29,9	-13,2
	3.2.	Урсгал шилжүүлэг	163,3	53,8	580,7
B.	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		79,8	342,1	1,203,9
	1.	Хөрөнгө оруулалт	68,2	283,3	700,4
	2.	Их засвар	17,8	5,8	7,6
	3.	Хөрөнгийн бусад зардал	-3,6	52,9	9,3
	4.	Гадаад төслийн зээлээр санхүүжих хөрөнгө оруулалт	-2,6	0.0	486,6
B.	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ		129,1	337,0	-364,8
	1.	Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	201,9	337,0	-415,0
	2.	Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.0	0.0	50,2

Нэгдсэн төсвийн нийт зарлагын бүлгийн зардлуудын өсөлтийг хурдыг өмнөх оныхтой харьцуулахад нийт зарлага 2011 онд 828.2 тэрбум төгрөгөөр өсч байсан бол 2012 оны төсөлд 2180.7 тэрбум төгрөг буюу 2.6 дахин, урсгал зарлага 9 дахин, хөрөнгийн зардал 3.5 дахин өссөн дүнтэй гарсан бол эргэж төлөгдөх цэвэр зээл 1.1 дахин буурсан байна.

Өмнөх жилүүдэд нэгдсэн төсвийн зарлагын өсөлт өндөр байсан хэдий ч 2012 оны төсвийн төсөлд тусгагдсан шиг өндөр өсөлт бараг байгаагүй байна. Доорхи графикт /Зураг 3.1./ 2003 оноос 2012 он хүртэл нэгдсэн төсвийн нийт зарлага, урсгал зарлага, хөрөнгийн зардал, цэвэр зээл зэргийн өсөлт бууралтийг дүрслэн үзүүлээ. 2003 оноос хойш нийт зарлага 11.5 дахин, урсгал зарлага 10.7 дахин, хөрөнгийн зардал 26.4 өссөн дүнтэй байхад цэвэр зээл харилцан адилгүй тухайн жилийнхээ зээлийн хэмжээнээс хамаарч өсч, буурсан байна.

Зураг 3.1. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн өсөлт (Тэрбум төгрөгөөр)



ДНБ, Төсвийн нийт зарлага, урсгал зардалын өсөлтийг 2004-2012 он хүртэл харьцуулан шинжиллээ. Сүүлийн жилүүдэд ДНБ тасралтгүй өссөн дүнтэй байгаа бөгөөд нийт зарлага 2009 онд -5.3 хувиар буурч харин урсгал зардал тогтмол өссөн байна.

Доорх хүснэгт /Хүснэгт 3.2/-ээс харахад сүүлийн жилүүдэд нийт зарлага болон урсгал зардал ДНБ-ний өсөлтөөс илүү хурдтай өсч байсан бөгөөд 2012 ДНБ 77.2 хувь буюу 18003.3 тэрбум төгрөгт хүрэхээр тооцсон нь урьд өмнө байгаагүй өндөр өсөлт юм. ДНБ, нийт зарлага, урсгал зардалын өсөлтийг хүснэгт болон график /Зураг 3.2/-аар үзүүлээ.


#### Хүснэгт 3.2.

- ДНБ, төсвийн нийт зарлага ба урсгал зардалын өсөлт оны үнээр, хувиар (Тэрбум төгрөгөөр)

		2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011 тод	2012 төсөл
ДНБ	оны үнээр	1910.9	2266.5	3714.9	4599.5	6019.8	6055.7	7171.4	10157.2	18003.3
	хувиар	30.8	18.6	63.9	21.8	35.4	0.6	18.4	41.6	77.2
ТНЗ	оны үнээр	752.5	764.6	1237.0	1747.3	2466.7	2336.6	3080.7	4912.3	7093.0
	хувиар	22.1	1.6	61.8	41.3	41.2	-5.3	31.8	59.4	44.3
ТУЗ	оны үнээр	538.7	600.3	982.3	1367.6	1761.1	1788.1	2256.6	3295.4	4637.1
	хувиар	23.9	11.4	63.6	39.2	28.8	1.5	26.2	46.0	40.7

\*\*\*

Зураг 3.2. ДНБ, төсвийн нийт зарлага ба урсгал зардлын өсөлтийн хурд, хувиар




Төсвийн нийт зарлага, урсгал зардал 2003-2006 онд ДНБ-ээс бага хувь хэмжээгээр нэмэгдэж байсан бол 2007 оноос илүү хувь хэмжээгээр өсч байсан ч 2012 оны төсвийн төсөлд ДНБ 2011 оныхоос 77.2 хувиар өсөхөөр төсөвлөгдсөн байна.

ДНБ-нд эзлэх зарлагын хувь хэмжээ 2012 онд 39.4 хувь болж Засгийн газрын 33 хувиас хэтрүүлэхгүй байх бодлогоос давж төсөвлөгдсөн байна. ДНБ-д эзлэх хувь хэмжээ нэмэгдэх болсон шалтгааныг Монгол Улсын эдийн засгийн хурдацтай өсөлтийн суурийг бий болгох, дэмжих, бэхжүүлэх, эдийн засгийн гүн хямралаас ангижрах чиг баримжаатай “тэлсэн” сангийн бодлогын хүрээнд эдийн засгийн бодит сэргэлт ажиглагдаж байгаа тул цаашид төсвөөр дамжуулан эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах бодлогыг хэрэгжүүлхээр ажиллаж байгаагаар холбон тайлбарласан байна.

2012 онд ДНБ-ийг 18003.3 тэрбум төгрөг байхаар тооцож түүнд эзлэх нийт зарлага болон урсгал зарлагын эзлэх хувь хэмжээг өмнөх онуудтай харьцуулан гаргалаа. ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлагын хэмжээг бууруулах бодлогыг Засгийн газраас баримтлаж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа юм. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаснаар бол ирэх жилүүдэд бууруулахаар зорилт тавьж байгаа боловч ДНБ-ний өсөлт удааширч төсвийн зарлагын хувь хэмжээ нэмэгдсээр байвал тодорхой үр дүнд хүрч чадахгүй юм.

Зураг 3.3. ДНБ-д эзлэх нийт зарлага, урсгал зардлын хувь



### 3.1.1. Урсгал зардал


Нийт зарлагад эзлэх урсгал зарлагын тоон үзүүлэлтүүдийг дээрх хүснэгт болон графикт тодорхой тусган харуулсан байгаа. Харин Урсгал зарлагын бүлгийн зардлуудын өсөлт, бууралтын харилцан хамаарлыг авч үзье.

2006 оноос 2012 он хүртэл урсгал зардал 4.7 дахин, хөрөнгийн зардал 12.4 дахин нэмэгдсэн байна. 2011 оныхоос урсгал зардал өсөхөд барааны үйлчилгээний зардалын зүйл ангийн зардлууд болох цалин хөлс 446.3 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 186.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Урсгал зардалын дүнд хамгийн их өсөлттэй гарсан зардал болох бараа үйлчилгээний зардал 620.3 тэрбум төгрөг буюу 41.6 хувь, татаас ба урсгал шилжүүлэг 567.6 тэрбум төгрөг буюу 24.3 хувь, тус тус өсч харин зээлийн үйлчилгээний төлбөр 191.1 тэрбум төгрөг болж өссөн байна. /Зураг 3.4 дээрх зардлуудын өсөлт, бууралтыг харна уу/

Дээрхи зардлууд өсөхөд 2012 оны төрийн албан хаагчдын цалинг нэмэх, мөн хүний хөгжил сангийн мөнгийг 2012 онд 892.1 тэрбум төгрөг, өндөр насты тэтгэвэр нэмэх, сонгуулийн үйл ажиллагааны зардал, оюутны тэтгэлэг зэрэг олон зүйлээс хамааран өсч байгаа бөгөөд бараа үйлчилгээний бусад зардал доторхи зарим зардлууд зах зээл дэх бүтээгдэхүүний үнийн өсөлт болон бусад хүчин зүйлээс хамаарч нэмэгдсэн байна.

Татаас ба урсгал шилжүүлэг нэмэгдэхэд татаас 446.2 тэрбум төгрөгөөр, засгийн газар хоорондын шилжүүлэг 221.0 тэрбум төгрөгөөр, өрх гэрт олгох шилжүүлэг 567.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Өрх гэрт олгох шилжүүлгийн бүлгийн зардлууд болох тэтгэвэр тэтгэмжийн зардал өмнөх оныхоос 207.5 тэрбум төгрөг болж үүн дотор өндөр настны тэтгэвэр 128.6 тэрбум төгрөгөөр, тахир дутуу бологсдын тэтгэвэр 36.5 тэрбум төгрөгөөр, цэргийн тэтгэвэр 13.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэн төсөвт тусгагдсан нь дээрх зардалууд өсөхөд нөлөөлсөн байна.

Зураг 3.4. Урсгал зардлын бүлгийн зардлуудын өсөлт, бууралт



### 3.1.2. Хөрөнгийн зардал ба цэвэр зээл

2011 онд ДНБ -ий 11.7 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг хөрөнгө оруулалтанд зарцуулахаар тодотголд тусгасан бөгөөд 2012 онд 13.3 хувь байхаар батлсан бөгөөд хөрөнгө оруулалтын зардал 72.1 хувиар, их засвар 14.5 хувиар, хөрөнгийн бусад зардал 13.3 хувиар, гадаад төслийн зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт 522.6 хувиар тус бүр нэмэгдсэн.

Зураг 3.3. Хөрөнгийн зардал ба цэвэр зээлийн өсөлт (Тэрбум төгрөгөөр)

	2008		2009		2010		2011 тод		2012	
	тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь
Хөрөнгийн зардал	624.4	108%	460,6	-26.2%	590.6	28,2%	1187.1	100.9%	2390.9	101.4%
1 Хөрөнгө оруулалт	482.6	101.7%	396.6	-17.8%	515.2	29.9%	971.6	88.5%	1672.1	72.1%
2 Их засвар	27.5	-3.1%	11.7	-57.4%	30.2	158.1%	52.5	73.8%	60.1	14.5%
3 Хөрөнгийн бусад зардал	94.0	1005%	25.5	-72.8%	15.8	-38.8%	69.8	341.7%	79.1	13.3%
4 Гадаад төслийн зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт	20.1	-13.3%	26.6	32.3%	29.4	10.5%	93.1	216.6%	579.7	522.6%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	81.1	1.3%	87.9	8.3%	233.3	165.4%	429.8	84.2%	65.1	-84.8%
1 Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	16.7	125.6%	1.0	-94%	184.2	99.4%	426.9	131.7%	11.9	-97.2%
2 Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	64.5	-11.2%	86.9	34.7%	49.1	-43.4%	2.9	-94.1%	53.1	1731%

Хөрөнгө оруулалтын зардал төсвийн дунд хугацааны мэдэгдэлтэй нийцэж байгаа бөгөөд цаашид тооцоо судалгаа, үнэслэл муутай хөрөнгө оруулалтыг арга хэмжээг төсөвт суулгахгүй байх нь чухал юм.

Эргэж төлөгдөх цэвэр зээл 2011 онд 429.8 тэрбум төгрөг байхаар тодотгосон бол 2012 онд 65.1 тэрбум төгрөг болж 84.8 хувиар бууруулжээ. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл 2011 онд 426.9 тэрбум төгрөг байхаар тодотгосон бол 2012 онд 11.9 тэрбум төгрөг буюу 97.2 хувь болж бууруулж гадаадцэвэр зээл 53.1 тэр бум төгрөг буюу 17 дахин нэмэгдэж төсөлөгдсөн байна.

### 3.2. Улсын болон орон нутгийн төсөв

Улсын төсвөөс 2012 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 5,587,950.7 сая төгрөгөөр баталсан байна. Улсын төсвийн нийт зарлагын ДНБ, Нэгдсэн төсвийн нийт зарлагад элэх хувь хэмжээ мөн өсөлтийн хувийг доорхи хүснэгтэд харууллаа. 2003 онд Улсын төсвийн ДНБ –д эзлэх хувь 40.1 байсан бол 2005, 2008, 2009 онуудад 30 хувиас доош бууж харин бусад жилүүдэд 37-31-ийн хооронд хэлбэлзэж дүхэндэй байхад нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь хэмжээ нь 2003-2009 онуудад тогтмол буурч байсан бол 2010 оноос эргээд өссөн дүнтэй байна. /Хүснэгт 3.4-өөс харна уу/


Улсын төсвийн нийт зарлага				
	тэрбум төг	өсөлтийн хувь	ДНБ-нд эзлэх %	НТЗ-д эзлэх%
2003	585.4	-	40.1	95.1
2004	711.2	21.4	37.2	94.5
2005	717.8	0.9	25.8	93.8
2006	1176.7	38.9	31.7	95.1
2007	1652.9	40.4	35.9	94.5
2008	1745.5	5.6	28.5	70.7
2009	1746.6	0.1	27.8	74.7
2010	2423.1	38.7	33.8	76.8
2011	3591.1	48.2	35.4	75.1
2012	5587.9	55.6	31.0	78.8

#### Хүснэгт 3.4. Улсын төсвийн ДНБ, НТНЗ-д эзлэх хувь хэмжээ болон өсөлтийн хувь

Монгол улсын засгийн газрын дунд хугацааны зорилтод засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг боловсронгуй болгон, орон нутгын бие даасан байдлыг хангаснаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна гэж заасан байна. Монгол Улсын хувьд орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ улсын төсвийн зарлагаас харьцангуй бага байгаа нь иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг Засгийн газар голчлон санхүүжүүлдэгийн илэрхийлэл юм.

Сүүлийн арван жилийн дунджаар ДНБ-д улсын төсвийн зарлагын эзлэх хувь хэмжээ 33.4 хувь байгаа бол орон нутгийн төсвийн зарлагын хувь хэмжээ 6,6 хувь буюу ДНБ -д эзлэх улсын төсвийн зарлага орон нутгийн төсвийн зарлагаас 5 дахин их байна. Орон нутгийн хариуцан нийлүүлж байсан бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхой хэсгийг 2002 оны ТБУСТ хуулиар засгийн газар хариуцах болсноор ДНБ -д эзлэх улсын төсвийн зарлагын хэмжээ өсч харин орон нутгийн төсвийн зарлагын ДНБ -д эзлэх хэмжээ 75 хувиар буурсан байна. Улс орны төвлөрсөн болон төвлөрсөн бус удирдлагатайг ДНБ-д орон нутгийн төсвийн орлого, зарлагын эзлэх хувь хэмжээгээр илэрхийлдэг. /Улсын төсөв болон орон нутгийн төсвийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг Зураг 3.5-аас харна уу/

#### Зураг 3.5. Улсын ба орон нутгийн төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ







Орон нутаг үндэсний нийт баялгийн маш бага хувийг захиран зарцуулж байгаа бөгөөд орон нутаг нь санхүүгийн талаар бие даасан бус байгаа нь үүнээс харагдаж байна. Орон нутгийн төсвийн зарлага нь 2012 онд ДНБ-ий 4 хувийг эзэлж байгаа нь бага үзүүлэлт юм. Мөн улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх орон нутгийн зарлагын хэмжээ 2002 онд 30.8 хувь байсан бол 2011 оны байдлаар 10.4 хувь, 2012 онд 10.2 хувь болж буурсан байна. 2012 онд орон нутгийн төсөвт дэмжлэг болгож 1 тэрбум төгрөг хуваарилаж байгаа боловч энэ нь нийт тийм төсвийн нийт дүнд эзлэх хувьд нөлөөлхгүй байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлын 78.2 хувийг 2008 онд, 87.5 хувийг 2009 онд, 93.7, хувийг 2010 онд, 75.0 хувийг 2011 онд, 70.8 хувийг 2012 онд тус төсвийн урсгал зардал эзэлж байгаа бол орон нутгийн нийт төсвийн зарлагад эзлэх хөрөнгийн зардлын хэмжээ 2008 онд 21,6 хувь, 2009 онд 12.5 хувь, 2010 онд 6.1 хувь болж буурч байсан боловч 2011 онд 24.9 хувь, 2012 онд 29 хувь болж нэмэгдсэн дүнтэй байна.

ТБУСТ хууль батлагдан гарсанаас хойш орон нутгийн төсвийн зарлагын дийлэнх хувь орон нутгийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгаа бөгөөд энэ дүн сүүлийн жилүүдэд өсч, харин орон нутгийн төсвийн зарлагын багахан хувийг эзэлдэг хөрөнгийн зардлын хувь хэмжээ буурсаар байсан боловч 2011-2012 онд /Зураг 3.6-аас харна уу/ нэмэгдсэн байна.

**Зураг 3.6. Орон нутгийн төсвийн урсгал зардалын бүлгийн зардлуудын динамик**  
(Тэрбум төгрөгөөр)





2012 оны байдлаар нийт урсгал зардлын 40 хувийг бараа, үйлчилгээний зардал, 59.9 хувийг татаас ба урсгал шилжүүлэг эзэлж байна. Татаас шилжүүлэг нэмэгдэхэд орон нутгийн төсөвт өгөх татаас өнгөрсөн оноос нэмэгдэж байгаатай холбоотой юм. Төсвийн орлого бүрдүүлэлт 2007, 2008 онуудад харьцангуй өндөр буюу орон нутагт хөрөнгө оруулалтад тодорхой санхүүжилт хийх боломжтой байсан үе бөгөөд 2009 онд болсон эдийн засгийн хямрал, төсвийн алдагдал зэргээс шалтгаалан энэ байдал муудсан ч 2011 оны төсөвт 106.6 тэрбум төгрөг буюу орон нутгийн нийт төсвийн 25 хувь, 2012 он 211 тэрбум төгрөг буув орон нутгийн нийт төсвийн 29.0 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр тусгасан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварт зориулж нийт 210,9 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа нь хөрөнгө оруулалт орон нутаг руу чиглэж байгааг харуулж байна.



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН